



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2003 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дахь заалт, Засгийн газрын 2000 оны 185, 2003 оны 7 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газрыг Тамгын хэлтэс, Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс, Нийгэм, эрүүл мэндийн хяналтын хэлтэс, Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтэс, Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс, Төв лабораторитойгоор ажиллуулж, удирдлагын орон тоог дарга 1, орлогч дарга 2, орон тооны хязгаарыг 215 хүртэл /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ байхаар тус тус тогтоосугай.

Хоёр. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар байгуулагдсантай холбогдуулан эрхлэх ажил, чиг үүрэг, бүтэц орон тоо нь өөрчлөгдсөн тул Г.Галсанпунцагийг 2003 оны 1 дүгээр сарын 15-наар тасалбар болгон Захирагчийн ажлын албаны Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын, Ч.Баттогтохыг 2003 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөр тасалбар болгон Санхүүгийн хяналт шалгалтын газрын даргын, Н.Лхагвасүрэнг Мал эмнэлэг, хяналтын газрын даргын үүрэг гүйцэтгэгчийн, Г.Бүдрагчааг Байгаль орчин, экологийн хяналтын газрын даргын үүрэгт ажлаас 2003 оны 1 дүгээр сарын 31-нээр тасалбар болгон тус тус чөлөөлж, Ч.Баттогтохыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын мэдэлд шилжүүлсүгэй.

Гурав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн "м", "ү" заалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан "Байгаль орчны газар"-ын даргаар Г.Бүдрагчааг, "Мал эмнэлэг, үржлийн газар"-ын даргаар Н.Лхагвасүрэнг 2003 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн томилон ажиллуулж, нийслэлийн Засаг даргын 2002 оны 433 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан цалин, нэмэгдлийг олгосугай.

Дөрөв. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Мэргэжлийн хяналтын хэлтэст ажиллаж байсан 13, Байгаль орчин экологийн хяналтын газар болон дүүргийн байгаль орчны хяналт хариуцсан байцаагч 17, Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба, дүүргүүдийн хөдөлмөрийн албаны 19, Санхүүгийн хяналт шалгалтын газар, дүүргийн санхүүгийн хяналтын тасгийн 41, Мал эмнэлгийн

0200180

хяналтын газрын 18, Боловсролын газрын 2, Багануур дүүргийн Мэргэжлийн хяналтын албаны 26, Эрүүл мэндийн хяналтын албаны 185 нийт 321 албан хаагчдыг төсвийн хамт 2003 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөр тасалбар болгон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын мэдэлд шилжүүлэхийг дээрх байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.

Тав. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан орон тооны хязгаарыг Захирагчийн ажлын албанд 33, Байгаль орчны газарт 41, Хөдөлмөр нийгэм хамгааллын албанд 5, Мал эмнэлэг, үржлийн газарт 22, Боловсролын газарт 29 хүртэл байхаар тус тус тогтоон, байгууллагын дүрэм, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээндээ зохицуулалт хийж ажиллахыг дээрх байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

Зургаа. Бүтцийн өөрчлөлт орж байгаа байгууллагуудын үндсэн болон эргэлтийн хөрөнгө, төсвийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулж шийдвэрлэхийг Засаг даргын орлогч Ч.Сумаахүүд үүрэг болгосугай.

Долоо. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны Байгаль орчин, экологийн хяналтын газрын дүрэм, орон тоог батлах тухай" 07, Мал эмнэлэг, хяналтын газрын дүрэм, орон тоог батлах тухай 14, Хөдөлмөр нийгмийн хамгааллын албаны дүрэм, орон тоог батлах тухай 15, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрэм, Мэргэжлийн хяналтын хэлтсийн дүрмийг баталсан 31 дүгээр захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БОГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



М.ЭНХБОЛД